

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2021.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/2/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Монгол Улсын Ерөнхий Сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Б.Нарангэрэл

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төсвийн ерөнхийлөн захирагч	1	1				1			
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	4	3	1			2	1		
3	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	5	4	1			3	1		
4	Төсвийн шууд захирагч	4	3	1			3			
	ДҮН	14	11	3			9	2		

Гурав. Аудитын үр дүн

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

№	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Төсвийн ерөнхийлөн захирагч	2		2							
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	20	698.0	12	616.1	2	18.5	6	63.4		
3	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж	28	3,155.2	19	227.6	1	2.3	8	2,925.3		
4	Төсвийн шууд захирагч	14	4,124.2	5	97.8	4	3,737.5	5	288.9		
	ДҮН	64	7,977.4	38	941.5	7	3,758.3	19	3,277.6		

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулбал:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд өмнөх онуудаас шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 77,601.9 сая төгрөгийн дуусаагүй барилга, байгууламж бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасныг мөрдлөг болгоогүй.

Шийдвэрлэсэн нь: Шилжиж ирсэн дуусаагүй барилгын хадгалалт хамгаалалт, ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх зөвлөмж өгөх;

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "энэ хуулийн 3.1.1-д Төсвийн байгууллага албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх;



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

2021. 04. 26 № 1318
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink, appearing to read 'Д.ЗАНДАНБАТ', is written over a faint red rectangular stamp. The signature is stylized and cursive.

Д.ЗАНДАНБАТ